



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Түдэвтэй сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/146/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraad@audit.gov.mn

Аудитын менежер :Х.Болдбаатар

Утас:99105506

Цахим хаяг: Boldbaatar.kh@audit.gov.mn

Аудитор: Д.Пүүжмаа

Утас:99080797

Цахим хаяг: puujmaad@audit.gov.mn:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улаангай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

Бодл. 02.21 № 129

танай _____ -ны № _____ -т

ТҮДЭВТЭЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.БАДАМХАНД-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түдэвтэй сумны Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Түдэвтэй сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Түдэвтэй сумын Засаг даргын Тамгын газар нь 662,8 сая төгрөгийн хөрөнгө, 18,8 сая төгрөгийн бараа материал хандив тусламжаар ирснийг данс бүртгэлд тусгаж, 2,5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан байна.

Аудитын гол асуудал

Түдэвтэй сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлийг шалгахад цалин шимтгэлийг зөрүүтэй тооцоолсон, бараа материалын тайланг буруу гаргасан, төсвийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг алдаа, зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Түдэвтэй сумын Засаг даргын Тамгын газар нь үйл ажиллагааны мөнгөн орлогыг төлөвлөгөөний дагуу бүрэн зарцуулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:\disk\Албан бичиг\Дүгнэлт

812502293

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-ҮНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	65,836,880.00	85,666,102.99
33	АВЛАГА	-	205,472.99
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	205,472.99
35	БАРАА МАТЕРИАЛ	65,836,880.00	66,590,630.00
354	Хангамжийн материал	56,736,880.00	57,490,630.00
35410	Бичиг хэргийн материал	1,737,550.00	1,604,550.00
35420	Аж ахуйн материал	33,576,450.00	34,203,200.00
35470	Бусад хангамжийн материал	21,422,880.00	21,682,880.00
35600	Мал амьтад	9,100,000.00	9,100,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	-	18,870,000.00
36300	Тэжээлийн нөөц	-	15,351,000.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	-	3,519,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,985,996,206.33	2,552,496,760.11
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,985,996,206.33	2,552,496,760.11
392	Биет хөрөнгө	1,980,525,282.35	2,353,951,925.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,646,372,403.00	1,698,377,138.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(193,870,601.71)	(236,763,836.65)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	309,807,300.00	506,236,009.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	(100,732,537.50)	(127,268,659.89)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	90,391,312.40	289,694,353.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,788,048.88)	(53,341,463.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,676,075.00	45,176,075.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,577,791.21)	(20,003,988.59)
39214	Бусад үндсэн хөрөнгө	348,768,035.93	379,373,385.93
39215	Хуримтлагдсан элэгдэл	(108,080,564.69)	(129,086,787.18)
39217	Ном	1,559,700.00	1,559,700.00
393	Биет бус хөрөнгө	5,470,923.98	198,544,834.24
39301	Програм хангамж	9,024,500.00	9,024,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,553,576.02)	(4,983,665.76)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	194,504,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,051,833,086.33	2,638,162,863.10
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,057,088.76	(0.00)
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,057,088.76	(0.00)
413	Өглөг	6,057,088.76	(0.00)
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	6,057,088.76	(0.00)
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,045,775,997.57	2,638,162,863.10
51	Засгийн газрын хувь оролцоо	2,045,775,997.57	2,638,162,863.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	507,582,219.61	507,582,219.61
51101	Өмч: - төрийн	507,582,219.61	507,582,219.61
512	Хуримтлагдсан үр дүн	1,427,863,858.22	2,020,250,723.75
51210	Өмнөх үеийн үр дүн	294,615,972.57	1,427,863,858.22
51220	Тайлант үеийн үр дүн	133,247,885.65	592,386,865.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	110,329,919.74	110,329,919.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,051,833,086.33	2,638,162,863.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	841,949,021.20	1,453,238,245.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	185,346,400.00	681,660,635.20
120	Нийтлэг татварын бус орлого	185,346,400.00	681,660,635.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	185,346,400.00	681,660,635.20
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,760,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	175,586,400.00	681,660,635.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	656,602,621.20	771,577,610.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,500,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,500,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,238,321.20	33,340,198.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,238,321.20	33,340,198.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	644,864,300.00	738,237,412.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	644,864,300.00	738,237,412.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	707,386,135.55	860,851,379.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	707,386,135.55	860,851,379.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	602,702,272.64	796,017,341.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	342,872,139.13	498,637,466.12
210101	Үндсэн цалин	237,105,944.26	331,381,250.73
210102	Нэмэгдэл	100,170,373.31	161,347,965.39
210104	Урамшуулал	5,595,821.56	5,908,250.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,804,200.00	61,730,514.88
210201	Тэтгэврийн даатгал	29,096,200.00	42,362,657.09
210202	Тэтгэмжийн даатгал	4,194,900.00	4,983,842.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,803,500.00	2,623,345.62
210204	Ажилгүйдлийн даатгал	700,900.00	2,351,690.26
210205	Эрүүл мэндийн даатгал	7,008,700.00	9,408,979.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,881,711.96	35,740,950.48
210301	Гэрэл, цахилгаан	3,372,551.96	4,322,212.44
210302	Түлш, халаалт	24,509,160.00	31,418,738.04
2104	Хангамж, бараа материалын зардал	29,601,365.00	29,559,498.00
210401	Бичиг хэрэг	2,566,540.00	4,312,800.00
210402	Тээвэр, шатахуун	16,646,584.00	19,440,048.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,262,800.00	3,235,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,125,441.00	2,570,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	890,200.00	722,700.00
210604	Урсгал засвар	890,200.00	722,700.00
2107	Томилолт, зочны зардал	3,999,200.00	9,164,000.00
210702	Дотоод албан томилолт	3,999,200.00	9,164,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,404,800.00	2,826,425.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,530,800.00	1,917,525.00
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	469,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	227,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,800.00	73,800.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	103,400.00	-
210807	Газрын төлбөр	-	138,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	150,248,656.55	157,635,787.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,412,830.96	47,065,705.74
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	69,300.00	230,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	91,766,525.59	110,340,081.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	104,683,862.91	64,834,038.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,191,300.00	33,186,912.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	96,191,300.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		33,186,912.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,492,562.91	31,647,126.03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,492,562.91	31,647,126.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>134,562,885.65</u>	<u>592,386,865.53</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>134,562,885.65</u>	<u>592,386,865.53</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	666,362,621.20	771,577,610.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,760,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	9,760,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,760,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,760,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	656,602,621.20	771,577,610.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,500,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,500,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,238,321.20	33,340,198.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,238,321.20	33,340,198.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	644,864,300.00	738,237,412.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	644,864,300.00	738,237,412.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	645,772,621.20	757,527,610.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	645,772,621.20	757,527,610.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	541,088,758.29	692,693,571.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	342,872,139.13	492,293,978.99
210101	Үндсэн цалин	237,105,944.26	350,085,775.96
210102	Нэмэгдэл	100,170,373.31	136,299,953.03
210104	Урамшуулал	5,595,821.56	5,908,250.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,804,200.00	68,208,600.00
210201	Тэтгэврийн даатгал	29,096,200.00	46,381,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,194,900.00	5,456,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,803,500.00	3,147,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	700,900.00	2,309,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,008,700.00	10,913,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,516,500.00	41,138,512.44
210301	Гэрэл, цахилгаан	3,372,551.96	4,322,212.44
210302	Түлш, халаалт	26,143,948.04	36,816,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,527,847.20	23,353,524.80
210401	Бичиг хэрэг	2,792,990.00	2,779,300.00
210402	Тээвэр, шатахуун	13,472,057.20	17,315,024.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,262,800.00	3,259,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,228,200.00	1,788,200.00
210604	Урсгал засвар	1,228,200.00	1,788,200.00
2107	Томилолт, зочны зардал	3,999,200.00	9,164,000.00
210702	Дотоод албан томилолт	3,999,200.00	9,164,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,509,300.00	5,830,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,535,300.00	4,767,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	469,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	227,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,800.00	73,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.00	154,100.00
210807	Газрын төлбөр	-	138,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	91,631,371.96	50,916,755.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	91,445,971.96	50,613,455.74
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	185,400.00	303,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	104,683,862.91	64,834,038.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,191,300.00	33,186,912.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	96,191,300.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	33,186,912.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,492,562.91	31,647,126.03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,492,562.91	31,647,126.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	20,590,000.00	14,050,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	20,590,000.00	14,050,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,590,000.00	14,050,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	20,590,000.00	14,050,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,590,000.00	14,050,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(20,590,000.00)	(14,050,000.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	507,582,219.61	110,329,919.74	1,294,615,972.57	1,912,528,111.92
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	507,582,219.61	110,329,919.74	1,294,615,972.57	1,912,528,111.92
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	133,247,885.65	133,247,885.65
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	507,582,219.61	110,329,919.74	1,427,863,858.22	2,045,775,997.57
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	507,582,219.61	110,329,919.74	1,427,863,858.22	2,045,775,997.57
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	507,582,219.61	110,329,919.74	1,427,863,858.22	2,045,775,997.57
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	592,386,865.53	592,386,865.53
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	507,582,219.61	110,329,919.74	2,020,250,723.75	2,638,162,863.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	674,064,300.00	639,874,437.09	799,088,200.00	706,590,959.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	674,064,300.00	623,374,437.09	799,088,200.00	706,590,959.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	577,873,000.00	527,183,137.09	724,791,200.00	673,404,047.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	350,433,000.00	342,872,139.13	537,989,000.00	492,293,978.99
210101	Үндсэн цалин	261,122,800.00	237,105,944.26	382,218,100.00	350,085,775.96
210102	Нэмэгдэл	89,310,200.00	100,170,373.31	155,770,900.00	136,299,953.03
210104	Урамшуулал	-	5,595,821.56	-	5,908,250.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,804,200.00	43,804,200.00	68,208,600.00	68,208,600.00
210201	Тэтгэврийн даатгал	29,786,800.00	29,096,200.00	46,381,900.00	46,381,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,504,300.00	4,194,900.00	5,456,700.00	5,456,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,803,500.00	2,803,500.00	3,147,000.00	3,147,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	700,900.00	700,900.00	2,309,600.00	2,309,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,008,700.00	7,008,700.00	10,913,400.00	10,913,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,516,500.00	29,516,500.00	41,393,500.00	41,138,512.44
210301	Гэрэл, цахилгаан	4,777,200.00	3,372,551.96	4,777,200.00	4,322,212.44
210302	Түлш, халаалт	24,739,300.00	26,143,948.04	36,616,300.00	36,816,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,973,500.00	18,973,434.00	20,473,500.00	20,456,200.00
210401	Бичиг хэрэг	2,793,000.00	2,792,990.00	2,793,000.00	2,779,300.00
210402	Тээвэр, шатахуун	12,917,700.00	12,917,644.00	14,417,700.00	14,417,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,262,800.00	3,262,800.00	3,262,800.00	3,259,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,228,200.00	1,228,200.00	1,788,200.00	1,788,200.00
210604	Урсгал засвар	1,228,200.00	1,228,200.00	1,788,200.00	1,788,200.00
2107	Томилолт, зочны зардал	3,161,200.00	3,279,200.00	9,341,200.00	9,164,000.00
210702	Дотоод албан томилолт	3,161,200.00	3,279,200.00	9,341,200.00	9,164,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,388,000.00	8,509,300.00	7,328,000.00	7,263,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,700,000.00	7,535,300.00	6,200,000.00	6,200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	560,000.00	-	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	469,100.00	469,100.00	469,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	227,700.00	227,700.00	227,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,800.00	73,800.00	73,800.00	73,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.00	203,400.00	203,400.00	154,100.00
210807	Газрын төлбөр	138,300.00	-	138,300.00	138,300.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15,700.00	-	15,700.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	-	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	115,368,400.00	79,000,163.96	38,269,200.00	33,091,555.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	115,065,000.00	78,814,763.96	37,965,800.00	32,788,255.74
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	185,400.00	303,400.00	303,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96,191,300.00	96,191,300.00	74,297,000.00	33,186,912.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,191,300.00	96,191,300.00	74,297,000.00	33,186,912.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	96,191,300.00	96,191,300.00	-	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	-	74,297,000.00	33,186,912.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	16,500,000.00	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	16,500,000.00	-	-
223001	Бусад хөрөнгө	-	16,500,000.00	-	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	557,184,300.00	648,364,300.00	762,147,500.00	738,237,412.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	557,184,300.00	648,364,300.00	762,147,500.00	738,237,412.00
122005	Орон нутгийн төсвөөс	557,184,300.00	648,364,300.00	762,147,500.00	738,237,412.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33339524.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	33339524.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	33339524.80
2104	Хангамж, бараа материалын зардал	2897324.80
210402	Тээвэр, шатахуун	2,897,324.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	567000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	567,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29875200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,875,200.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	673.20
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	673.20
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	33340198.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33340198.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,340,198.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан аймгийн Түдэвтэй сумын ЗДТГ нь харьяалагдах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын тасаг албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны удирдлагыг мэдээллээр хангах үүргийг хэрэгжүүлдэг байгууллага юм.

“Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж мэргэшсэн төрийн албан хаагчаар төрийн албыг бүрдүүлэн иргэдэд төрийн үйлчилгээг ил тод шуурхай тэгш хүртээмжтэй хүргэх сум орон нутгаа хөгжүүлэх” гэсэн зорилгыг тавин ажиллаж байна.

2024 онд Түдэвтэй сумын ЗДТГ-аас “Иргэдэд төрийн үйлчилгээг ил тод шуурхай тэгш хүртээмжтэй хүргэх” гэж дэвшүүлсэн зорилтын хүрээнд үйл ажиллагааныхаа чиглэлийг тодорхойлж, 7 зорилтын хүрээнд 95 арга хэмжээг төлөвлөснөөс, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 91.7 хувиар дүгнүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Түдэвтэй сумын ЗДТГ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, зэрэг хуулиудыг голлон мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлээр дараах хууль, журамд өөрчлөлт орсон байна.

- Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн нэмэлт өөрчлөлт
- Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоол Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түдэвтэй сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын

дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Түдэвтэй сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 586.3 сая төгрөгөөр буюу 28.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	65,836.9	85,460.6	19,623.7
Үндсэн хөрөнгө	1,985,996.2	2,552,496.7	556,500.5
Нийт хөрөнгө	2,051,833.1	2,638,162.9	586,329.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,045,776.0	2,638,162.9	586,329.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,051,833.1	2,638,162.9	586,329.8

Бараа материал дансны үлдэгдэл 19.6 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 68.3 сая төгрөгийн бараа материал худалдан авч, сумын ОНХС-ын хөрөнгөөр 18.9 сая төгрөгийн бараа материал шилжүүлэн авч, 67.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны хувьд Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалт болон аймаг, сумын ОНХС-ын хөрөнгөөр 154.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч өгсөн, мөн өөрийн хөрөнгөөр 25.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бэлтгэснээс шалтгаалж 132.4 сая төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын дансны үлдэгдэл 2,051.8 сая төгрөг болж 133.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 809,7 сая , нийт зарлагыг 809,7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг батлахдаа өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн, 224.7 сая төгрөгөөр бууруулан/өсгөн 809.7 сая төгрөгөөр баталжээ. 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 08 тоот тогтоолоор сумын ИТХ-аар төсвийг тодотгон 14 сая төгрөгөөр хасагдуулж 795.7 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийн 95 арга хэмжээг санхүүжүүлэхээр 795.7 сая төгрөгийн төсөв баталсны 754.3 сая орон нутгийн төсвөөс, дээд шатны төсөв захирагчаас 41.4 сая төгрөгийн санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 663.8 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 41.1 сая төгрөг авч, нийт 738.8 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаандаа зарцуулж, 31.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 707.2 сая төгрөг буюу 95.7 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	552,542.8	519,509.7	33,033.1	94,02
2	80106-Багийн үйл ажиллагаа	159,107.8	155,817.7	3,290.1	97,9
3	81102- Засаг даргын нөөц сан	17,000.0	17,000.0	0	100
4	81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	6,525.0	1,358.4	5,166.5	20,8
5	80205 Мэдээлэл сурталчилгааны зардал	6,200.0	5,926.9	273.1	95,6
6	80802 Ажил олгогчоос олгох тэтшэмж урамшуулал	53,742.0	33,187	20,555.0	61,7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 23.2 сая төгрөг, , өмнөх оны үлдэгдэл малын тэжээл борлуулсны орлого 8.7 сая, хагас жилийн мал тооллогын зардал 1.2 сая, хүүхэд хамгааллын хамтарсан багийн зардал 0.3 сая нийт 33.3 сая төгрөгийг бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус байгууллагад тусгайлан хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Түдэвтэй сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Пүүжмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Түдэвтэй сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 03/10 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1,453.2 сая төгрөгийн 1.5 хувь буюу 21.7 сая сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар арга хэмжээ авч ажилласныг шалгахад хууль зөрчсөн алдаа илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хэрэгжилтийг шалгахад тайлант хугацаанд оруулах ёстой мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой алдаа зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Түдэвтэй сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудитыг хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	4	20,350.6	4	20,350.6	100
Албан шаардлага	12	47,983.7	12	47,983.7	100
Хариуцлага тооцуулах албан шаардлага	1	0	1	0	100
Нийт дүн	15	68,334.3	15	68,334.3	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулах алдаа илрээгүй.

Аудитаар нийт 17.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 16.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 0.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Төсвийн хэмнэгдсэн зардлаас 0.2 сая төгрөгийг хувь хүний орлогын албан татварт шилжүүлэн авлагаар тайлагнасан, амралтын цалинг 0.2 сая төгрөгөөр илүү тооцон албан хаагчид олгосон, зэрэг дэвийн нэмэгдлийг албан хаагчид 0.3 сая төгрөгөөр зөрүүтэй тооцон олгосон нь:

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв

зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, 16 дугаар зүйлийн 16.5.3-д “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын 2.5-д “Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3-т заасан төрийн албанд ажилласан болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин болон мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1, 23.2.2, 23.2.3-т заасан тусгай шаардлагыг хангасан төрийн захиргааны албан хаагчид доорх байдлаар албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгоно” гэж заасантай нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт: Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тойрогт ажиллах 2.7 сая төгрөгийн зардлыг төсвөөс гаргасан,, газрын дуудлага худалдааны орлогын 13.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, нярав бараа материалын тайланг үнэн зөв гаргаагүй зэрэг нь:

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана” 14.2-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө” гэж заасныг тус тус зөрчсөн байна

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Түдэвтэй сумын ИТХ-ын төлөөлөгчдийн тойрогт ажиллах зардлыг төсвөөс гаргасан	1	2,700.0			1	2,700.0						
Газрын даамал болон цагдаагийн албан хаагчид хөрөнгө худалдан авч өгсөн	1	13,550.0			1	13,550.0						
Нярав бараа материалын тайланг үнэн зөв гаргаагүй	1	0			1	0						
Зэрэг дэв дутуу тооцож олгосон	1	340.0	1	340.0								
Амралт илүү тооцон олгосон	1	174.4	1	174.4								
НДШ-ийг илүү тооцоолон авлага үүсгэсэн	1	205.5	1	205.5								
Дүн	6	16,969.9	3	719.9	3	16,250.0						

БОЛОВСРУУЛСАН : АУДИТОР

Д.ПҮҮЖМАА 2025.02.24

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР 2025.02.25

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА 2025.02.25

